

Б.Байгаль нар танилцуулж, Сонгинохайрхан дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй халдварт хамгааллын улсын байцаагч Н.Нандинцэцэг, Үйлдвэр худалдаа үйлчилгээний улсын хяналтын байцаагч Б.Бат-Эрдэнэ нар сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн талаар тайлбар танилцуулав.



Апу трейдинг ХХК, СХД-ийн дүүргийн Мэргэжлийн Хяналтын хэлтэстэй хамтран “Хүүхдийн хоол тэжээл, сүү, сүүн бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага” сэдвээр сургалт зохион байгуулав.

Тус сургалтыг 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Апу трейдинг ХХК-ийн хурлын зааланд зохион байгуулсан бөгөөд СХД-ийн Төрийн өмчит цэцэрлэгүүдийн няглан бодогч нар хамрагдсан. “Апу трейдинг” ХХК-ийн үйл ажиллагааны танилцуулгыг Хүнсний технологич Т.Сарантуяа, Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа аюулгүй байдал, технологи, чанарын хяналтын лабораторийн танилцуулгыг Чанарын албаны дарга Т.Золжаргал нар семинар танилцуулж, СХД-ийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй халдварт хамгааллын улсын байцаагч Н.Нандинцэцэг, Үйлдвэр худалдаа үйлчилгээний улсын хяналтын байцаагч Б.Бат-Эрдэнэ нар сүү, сүүн бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүйн шаардлага сэдвээр тайлбар танилцуулга хийллээ.

Үйлдвэрийн танилцуулга



Атар Өргөө ХК, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газартай хамтран “Хүүхдийн хоол тэжээл, гурил, гурилан бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага” сэдвээр сургалт зохион байгуулав. Тус сургалтыг 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Атар Өргөө ХК-ийн сургалтын зааланд зохион байгуулсан бөгөөд СХД-ийн Төрийн өмчит цэцэрлэгүүдийн няравууд хамрагдсан. “Атар өргөө” ХК-ийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн аюулгүй байдал, технологийн танилцуулгыг лабораторын эрхлэгч В.Баттуяа танилцуулж, НМХГ-ын Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Цэрмаа, Эрүүл мэнд, халдварт хамгааллын улсын байцаагч Г. Ариунаа нар танилцуулга хийллээ.



Талх чихэр ХК, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газартай хамтран “Хүүхдийн хоол тэжээл, гурил, гурилан бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага” сэдвээр сургалт зохион байгуулав.

Тус сургалтыг 2016 оны 10 дугаар сарын 14-ны өдөр Талх чихэр ХК-ийн сургалтын зааланд зохион байгуулсан бөгөөд СХД-ийн Төрийн өмчит цэцэрлэгүүдийн эрхлэгч, ахлах тогооч нар хамрагдсан. “Талх чихэр” ХК-ийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн аюулгүй байдал, технологийн танилцуулгыг Борлуулалтын албаны дарга Б.Баттулга, НМХГ-ын Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Цэрмаа, Эрүүл мэнд, халдварт хамгааллын улсын байцаагч Г.Ариунаа нар гурил, гурилан бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйн талаар танилцуулж, зөвлөмж зөвлөгөө өгсөн ба ETV, С1 телевизүүдтэй хамтран ажиллалаа. Мөн сургалтанд урилгаар Нийслэлийн



Боловсролын газрын Эрүүл ахуй аюулгүй байдлын хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Б.Энхтайван, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ахлах мэргэжилтэн Т.Оюунсувд, мэргэжилтэн Э.Амгаланбаатар оролцлоо.



СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2016 оны тендер шалгаруулалт:

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, Худалдан авах ажиллагаа сургалт зөвлөгөө өгөх төв ТББ зэрэг байгууллагуудад үнэлгээний хороонд ажиллах мэргэжилтэнг томилж өгөх хүсэлтийг хүргүүлэн хамtran ажилласан.

2016-Б/001 Нээлттэй тендер: “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын захирлын тушаалаар Үнэлгээний хороо байгуулах тухай хэлэлцэж ҮХ-ны дарга Б.Хэрлэнчимэг, ҮХ-ны нарийн бичгийн дарга З.Мөнхшүр, харилцан зөвшилцөнөөр ҮХ-ны гишүүн Г.Гончигдорж, ҮХ гишүүн Э.Жавхлан, Н.Отгонжаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллагдсан.

СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2016 оны 08 сарын 22-ноос 2016 оны 12 сарын 25-ны өдөр хүртэл нийт 4 сарын худалдан авалт 2016/Б/001 нээлттэй тендер шалгаруулалтыг 2016.07.08 өдөр 8 багцтайгаар зарласан. Тендерийн урилгыг Монголын Мэдээ сонин, Сангийн яамны хууль, худалдан авах ажиллагааны газрын E-procurement.mn сайтад хуулийн дагуу байршуулсан. Зарласан багцууд

- 1.Багц 001-01 Баруун бүсийн хонины мах багц
- 2.Багц 001-02 Зүүн бүсийн хонины мах багц
- 3.Багц 001-03 Үхрийн мах багц
- 4.Багц 001-04 Хүнсний ногооны багц
- 5.Багц 001-05 Будаа, гоймон багц
- 6.Багц 001-06 Жигнэмэг багц
- 7.Багц 001-07 Талх нарийн боовны багц
- 8.Багц 001-08 Сүү, сүүн бүтээгдэхүүний багц

СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2016/Б001 нээлттэй тендер шалгаруулалтанд нийт 2 байгууллага тендерт оролцох хүсэлт ирүүлсэн.

Тендерийн баримт бичиг хүлээн авах хуулийн хугацаа болох 2016.08.08-ны өдрийн 10:30 цагт нээлт хийж Ханбрэнд ХХК, Сүү ХК зэрэг 2 байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд үнэлгээний хороо баримт бичгүүдийг үнэлж, доорх дүгнэлтийг гаргасан.

- Сүү ХК нь: Тендерийн баримт бичигт ирүүлсэн Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн тодорхойлолтод 253,392,059 төгрөгийн дутуу, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолтонд 67,203,435 төгрөгийн дутуу үлдэгдэл байгаа нь хуулийн 14.1-д “Дараах нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ: ...14.1.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй...” гэж заасны дагуу ерөнхий нөхцөлийг хангаагүй гэж уг тендерээс татгалсан.
- Ханбрэнд ХХК нь: Тендерт оролцогчын санал болгож буй барааны тоо хэмжээ, нэр төрөл нь захиалагчийн худалдан авах барааны тоо хэмжээнээс дутуу санал болгосон нь тендерийн үнэлгээний зааврын 6-р зүйлд заасны дагуу бүрэн бус тендер ирүүлсэн байна. Мөн тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт 18.1 (б)-д “Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоог 2014 он, 2015 онуудын жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан.” ирүүлнэ гэж заасан. Тус байгууллага нь 2014 он, 2015 оны санхүүгийн аудитлагдсан тайланг Ай Эф Ти Ти ХХК-аар ирүүлсэн байна. Иймд санхүүгийн тайлан ирүүлээгүй гэж үзэж уг тендерээс татгалсан.

“Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах”, 2016-Б/001 дугаар бүхий тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул хуулийн 30.1-д заасны дагуу захиалагч бүх тендерээс татгалзаж, хуулийн 30.4.1-д заасны дагуу тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж дараагийн тендерийг худалдан авалтын үнийн дүнгээс хамаарч Нээлттэй болон Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулахаар болов.

2016-Б/002 Нээлттэй тендер: “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын захирлын 2016 оны 08 сарын 22 ны өдрийн А/50 тоот тушаалаар Үнэлгээний хороо байгуулах тухай хэлэлцэж ҮХ-ны дарга Б.Хэрлэнчимэг, ҮХ-ны нарийн бичгийн дарга З.Мөнхшүр, харилцан зөвшилцсөнөөр ҮХ-ны гишүүн Г.Гончигдорж, ҮХ гишүүн Э.Жавхлан, Н.Отгонжаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллагдсан.

СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2016 оны 10 сарын 10-наас 2016 оны 12 сарын 25-ны өдөр хүртэл нийт 2 сар 15 хоногийн худалдан авалтанд 2016/Б002 нээлттэй тендер шалгаруулалтыг 2016.08.23 өдөр 5 багцтайгаар зарласан. Тендерийн урилгыг Монголын Мэдээ сонин, Сангийн яамны хууль, худалдан авах ажиллагааны газрын E-procurement.mn сайтад хуулийн дагуу байршуулсан. Зарласан багцууд

1. Багц-01 Хонины мах баруун бүс
2. Багц-02 Хонины мах зүүн бүс

4. Багц-04 Будаа гоймон багц
5. Багц-05 Сүү сүүн бүтээгдэхүүн

СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2016/Б002 нээлттэй тендер шалгаруулалтанд нийт 16 байгууллага тендерт оролцох хүсэлт ирүүлсэн.

Тендерийн баримт бичиг хүлээн авах хуулийн хугацаа болох 2016.09.22-ны өдрийн 10:00 цагт нээлт хийж Хом плаза ХХК, Апу трейдинг ХХК, Цоргын-Ундарга ХХК, Баатарууд тэнгэр ХХК, Хулагу Холдинг ХХК, Ханбрэнд ХХК, Стандарт мах ХХК, Аль ХХК, Траст трейд ХХК, Монфрэш ХХК, Монсүү ХХК зэрэг 11 компани тендерийн баримт бичгээ цагтаа ирүүлсэн ба хоцорсон Траст трейд ХХК, Монфрэш ХХК, Монсүү ХХК компаний тендерийн материалыг тендерийн нээлтэн дээр хоцорсноор дурдаж тендерийн материалыг буцаан олгосон.

- Хоум плаза ХХК компани: Ирүүлсэн тендерийн баримт бичигт тендерийн баталгаа байхгүй байгаа нь тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа /цаашид ТОӨЗ гэх/-ны 21.1-д “ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь мөн ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ”. 21.5-д “Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангагүй гэж үзэж татгалзана.”, мөн техникийн тодорхойлолт нь шаардлагад нийцэхгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.3, 27.4-т заасны дагуу тус компанийн ирүүлсэн тендерээс татгалзсан.
- Апу трейдинг ХХК : Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа /цаашид ТОӨЗ гэх/-ны 18.1(б)" -д /Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2014 он, 2015 онуудын жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан / ирүүлнэ гэж заасны дагуу 2014 он 2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт ирүүлээгүй. Мөн тендерт оролцогчын санал болгож буй барааны тоо хэмжээ, нэр төрөл нь захиалагчийн худалдан авах барааны тоо хэмжээнээс дутуу санал болгосон нь тендерийн үнэлгээний зааврын 6-р зүйлд заасны дагуу бүрэн бус тендер ирүүлсэн, үндэслэлээр уг компаний ирүүлсэн тендерээс татгалзсан. Иймд тендерийн баримт бичгийн 31.1 (г), 31.2, 31.4-д заасны дагуу уг компаний ирүүлсэн тендерээс татгалзсан.
- Цоргын-Ундарга ХХК: Тус компани ирүүлсэн тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа нь 2016 оны 11 сарын 05 ны өдрийг дуустал гэсэн нь тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 21.2 "...Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 4-р бүлэг дэх тендерийн баталгааны маягтаар эсвэл тендер хүлээн авхаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.", Мөн хуулийн 20.5 "...Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тендерийн баталгаа нь энэ хуульд

заасан шаардлагыг хангаагүй бол захиалагч тухайн тендерээс татгалзана.” гэж заасны дагуу тус компаний ирүүлсэн тендерээс татгалзсан.

- Баатарууд тэнгэр ХХК: Уг компани ирүүлсэн тендерийн баримт бичиг Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид ТШӨХ гэх/-ийн ТОӨЗ 12.1 (ё)-д “Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: ... Санал болгож буй бүтээгдэхүүний гарал үүсэл болон ариун цэврийн гэрчилгээ...” ирүүлнэ гэж заасны дагуу танай компани санал болгож буй бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ нь баталгаажаагүй, мах махран бүтээгдэхүүний ариун цэврийн гэрчилгээ ирүүлээгүй. Мөн ТОӨЗ 12.1 (ё)-д “Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: ... Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын төв лабораторын санал болгож буй бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээ...” ирүүлнэ гэж заасны дагуу танай компаний санал болгож буй бүтээгдэхүүний мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт зөрчилтэй нь захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзах үндэслэл болно. Иймд тус компаний ирүүлсэн тендерээс татгалзсан.
- Хулагу Холдинг ХХК: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6 Тендерт оролцогч энэ хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ гэж заасны дагуу эрх бүхий эсэхээ мэдэгдсэн албан бичгээ ирүүлээгүй. Мөн тендерт оролцогчийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажсан техникийн тодорхойлт ирүүлээгүй. Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа /цаашид ТОӨЗ гэх/-ны 18.2(в) “....Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн гол тоног төхөөрөмжийн жагсаалт: Шаардлагатай. Үүнд: Захиалгат бараа бүтээгдэхүүнийг хуваарийн дагуу агуулахад тээвэрлэн хүргэх стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй байх шаардлагатай ба нотолгоо болгон тээврийн хэрэгслийн гэртчилгээг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ” гэж заасны дагуу нотлох баримтыг ирүүлээгүй. Иймд хуулийн 27.1.1, 27.3, 27.4 заасны дагуу тус компаний ирүүлсэн тендерээс татгалзсан.
- Хан брэнд ХХК: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6 Тендерт оролцогч энэ хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ гэж заасны дагуу эрх бүхий эсэхээ мэдэгдсэн албан бичиг ирүүлээгүй. Тендер хүчинтэй байх хугацааг дээрх хуулийн дагуу тодорхойлж, тендерийн маягтандaa тусгаагүй нь тендерийн баримт бичгийн тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТОӨЗ/-ны 20.1-д “Тендерийн хүчинтэй байх хугацаа нь тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.” гэж заасан. Аливаа тендерийн хүчинтэй байх хугацаа нь захиалагчийн тогтоосон хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана. Мөн техникийн тодорхойлтын бараа нийлүүлэлтийн хуваарийг гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулаагүй. Иймд дээрх үндэслэлүүдээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тухай хуулийн 27.1 27.3 27.4 заасны дагуу тус компаний ирүүлсэн тендерээс татгалзсан.

- Стандарт мах ХХК: Уг компанийй ирүүлсэн тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа нь 2016 оны 12 сарын 02 ны өдрийг дуустал гэсэн нь тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 21.2 "...Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 4-р бүлэг дэх тендерийн баталгааны маягтаар эсвэл тендер хүлээн авхаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.", Мөн хуулийн 20.5 "...Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тендерийн баталгаа нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол захиалагч тухайн тендерээс татгалзана." гэж заасны дагуу тус компаний ирүүлсэн тендерээс татгалзсан.
- Агь ХХК: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6 Тендерт оролцогч энэ хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ гэж заасны дагуу эрх бүхий эсхээ мэдэгдсэн албан бичгээ ирүүлээгүй. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл зарим бүтээгдэхүүн дээр байхгүй байгаа нь тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа /цаашид ТОӨЗ гэх/18.1(а) "...Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: Шаардлагатай. Эрх бүхий байгуулага /үйлдвэрлэгч/-ын бараа нийлүүлэх зөвшөөрөлтэй байх ба тухайн барааны гарал үүслийн бичиг, үйлдвэрлэгчийн кодууд тавигдсан байна." гэсэн шаардлагыг хангаагүй байна. Мөн тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа /цаашид ТОӨЗ гэх/-ны 18.1(г) Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2014 он 2015 он/ заасны дагуу сүүлийн 2 жилийн ижил төстэй ажлын мэдээлэл ирүүлээгүй. Иймд дээрх үндэслэлүүдээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1 27.3 27.4 заасны дагуу дээрх компани тендерээс татгалзсан.

"Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах", 2016-Б/002 дугаар бүхий тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул хуулийн 30.1-д заасны дагуу захиалагч бүх тендерээс татгалзаж, хуулийн 30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендерийн шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах" гэж заасны дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг үнэлгээний хорооны гишүүд "Хүнс Хангамж Төв" ОНӨААТҮГ-ын дарга Ш.Бурмаад зөвлөмж өгсөн.

2016 оны Харьцуулалтын аргын тендер: "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын захирлын 2016 оны 08 сарын 16 ны өдрийн А/49 тоот тушаалаар Үнэлгээний хороо байгуулах тухай хэлэлцэж ҮХ-ны дарга Б.Хэрлэнчимэг, ҮХ-ны нарийн бичгийн дарга З.Мөнхшүр, харилцан зөвшилцсөнөөр ҮХ-ны гишүүн Сондарьяа, ҮХ гишүүн М.Мөнхсайхан, Н.Отгонжаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллагдсан СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Харьцуулалтын тендерийн баримт бичиг болон үнийн санал ирүүлэх албан бичгийг 2016 оны 08 сарын 16 өдөр доорх багцаар компаниудад хүргүүлсэн. Үнд:

Багц/01 Тахианы махны багцад: Агмарко ХХК, Райзан стар ХХК, Капитал маркет ХХК

Багц/02 Хүнсний ногооны багцад: Оюу талст ХХК, Жаврай-Үр ХХК, Эм ти Эм Си ХХК

Багц/03 Нарийн ногооны багцад: Гэрэлт-Өртөөлөн ХХК, Дэвших-Ургац ХХК, Дэвших ХХК

Багц/04 Гурил багцад: Алейск-Импекс ХХК, Милл хаус, Арвин-Үндэс ХХК, Өег ХХК

Багц/05 Хуурай сүүний багцад: Монмасло ХХК, Бимэкс ХХК, Номин тав трейд ХХК

Багц/06 Жимс жимсгэний багцад: Гэрэлт-Өртөөлөн ХХК, Их-Өсөлт ХХК, Агмарко ХХК

Багц/07 Жимсний чанамал жүүсний багцад: Эко-Эрдэнэ ХХК, Номин тав трейд ХХК, Монфрэш ХХК

Багц/08 Жигнэмэг багцад: Кондитер-УБ ХХК, Монмасло ХХК, Органик хүнс трейд ХХК, Томбат ХХК, Бимэкс ХХК, Сет-Импекс ХХК

Багц/09 Талх нарийн боовны багцад: Суман гүн трейд ХХК, Атар-Өргөө ХХК, Талх чихэр, Евро Ази бид ХХК

Багц/10 Бусад хүнсний бүтээгдэхүүний багцад: Батсол ХХК, Монмасло ХХК, Урбанек ХХК, Агь ХХК, Домог-Интернэшнл ХХК

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйл 47.2.2 дахь заалтыг үндэслэн 3ӨВЛӨХ НЬ:

Нэг. Тендерийн үнэлгээний хорооны 2016 оны 08 дүгээр сарын 24-ны өдрийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн 2016 оны хичээлийн жилд СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах дараах байгууллагатай гэрээ байгуулахыг зөвлөв.

Багцын нэр, дугаар	Шалгарсан байгууллагын нэр
Багц-01 Тахианы мах	“Агмарко ХХК”
Багц-02 Хүнсний ногоо	“Оюу талст ХХК”
Багц-03 Нарийн ногоо	“Гэрэлт-Өртөөлөн ХХК”
Багц-05 Хуурай сүү	Домог интернешнл ХХК
Багц-06 Жимс жимсгэнэ	Их-Өсөлт ХХК

Багц-07 Жимсний шүүс	"Эко-Эрдэнэ ХХК"
Багц-08 Жигнэмэг	"Монмасло ХХК"
	"Томбат ХХК"
	Сет-Импекс ХХК
	"Кондитер УБ ХХК"
Багц-09 Талх нарийн боов	"Талх чихэр ХХК"
	"Атар Өргөө трейд"
	"Евро Ази Бид ХХК"
	"Суман гүн трейд ХХК"
Багц-10 Бусад хүнсний бүтээгдэхүүн	Мон масло ХХК
	Өөг-Импекс ХХК
	"Батсол ХХК"
	"Агъ" ХХК
	"Урбанек ХХК"

Хоёр. Дээрх байгууллагуудтай "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 29.2 дахь заалтын дагуу худалдан авах гэрээ байгуулан, захиалагчийн хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авахыг СХД-ийн "Хүнс Хангамж Төв" ОНӨААТҮГ-ын захирал /Ш.Бурмаа/-д үнэлгээний хорооны гишүүд зөвлөж ажилласан.

2016 оны байдлаар Нийслэл болон СХД-ийн хэмжээнд тодорхой газар нутагт 4 удаа нийтийн их цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэлээ. Улаанбаатар хотын Ерөнхий менежерээр батлуулсан удирдамж, хуваарийн дагуу Энхтайвны гүүрний баруун талд Жаргалант үйлчилгээний төвийн хойд хэсгээр дунд гол дагуу их цэвэрлэгээг 50 метр талбайн хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлүүлэх ажилд оролцож голын дагуу болон явган хүний замын ил задгай хог хаягдал, гялгар уут, шарилжыг цэвэрлэж тээвэрлүүлэн эрүүл цэвэр орчинг бүрдүүллээ. Манай байгууллага нь "Авто тав" ХК-ийн эзэмшлийн байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд улирал тутам СХД-ийн Засаг даргын захирамжийн дагуу байгууллагын ойр орчмын 50 метр талбайн хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлэх ажлыг зохион байгууллаа.



ОНӨААТҮГ-аас зохион байгуулсан спорт наадам

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийг хариуцан ажилладаг “Асгат”, “Өсвөр үе хүнс”, “Хүнс Хангамж төв”, “Багачууд хүнс” ОНӨААТҮГ тэдгээрийн ажилтан, албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлж, шилдэг баг тамирчдыг шалгаруулж урамшуулах уламжлалт ажил болгон зохион байгуулагддаг.


2016 оны 05 дугаар сарын 21-нд спорт тэмцээн нь Их засаг их сургууль дээр зохион байгуулагдаж нийт оноогоор “Тэргүүн” байр эзэлж өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнагдав.



Шинэ санаачлага, ур дүн:

1. “Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГазар нь СХД-ийн 44 цэцэрлэг, Нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны 74-р сургууль, Хүн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу хүнсний захиалгыг 7 хоног бүрийн Пүрэв, Баасан гаригт fsc_nuvq@yahoo.com цахим хаягаар хүлээн авч цахим захиалгын систем нь хоол үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний түүхий эд бүтээгдэхүүн, бараа материалын хэмжээ, агуулахын урсгалыг хянах боломжтой болгож захиалгатай холбоотой мэдээллийг

ил тод болгож байна. 2016 онд хүнсний бүтээгдэхүүний захиалгыг цахим хэлбэрт шилжүүлснээр доорх үр дүнд хүрсэн.




Бүтээгдэхүүн нийлүүлдэг нийт 47 харилцагч байгууллагуудаас цахим хаягаар захиалга өгдөг 41, утсаар захиалга өгдөг 6 байгууллага байгаа бөгөөд тус цэцэрлэгүүдэд 2017 онд хүнсний бүтээгдэхүүний захиалгыг нэгдсэн цахим хэлбэрт шилжүүлж ажиллах тухай албан шаардлагыг хүргүүлж ажиллаж байна.

2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах баримт бичгүүдийг онлайнаар илгээж хэвшив.

1. МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт
2. МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори дүгнэлт
3. Эрүүл ахуй нян судлалын хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн
4. Эрүүл ахуй хими хор судлалын хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн
5. Ургамлын эрүүл ахуй хорио цээрийн хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн
6. Технологи чанар хяналт сорилтын дүнгийн хуудас
7. Хилийн мэргэжлийн хяналтын хуудас
8. Max махан бүтээгдэхүүний ариун цэврийн гэрчилгээ
9. Мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ
10. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ

11. Агрохимиийн шинжилгээний дүн

Дээрх дүгнэлтүүдийг цэцэрлэгүүдэд хүнсний бүтээгдэхүүн түгээх бүрт цахим хэлбэрээр илгээн ажиллав.



3. “Хүнс–Хангамж төв” ОНӨААТҮГ нь мах, хүнсний ногоог зөөх, ачих, буулгах, тээвэрлэхэд дамжин бохирдолтоос сэргийлж чанар аюулгүй байдлыг хангуулах зорилгоор байгууллагын нэр хаягтай зориулалтын уутанд савлан түгээж хэвшүүлсэн.

Max, ногооны савлагаа







4. Аж ахуй нэгж, байгууллагуудад хийсэн хяналт, шалгалтын үр дүн

Байгууллагын дотоод хяналт шалгалтын журмын дагуу гэрээт цэцэрлэгүүдэд хүнсний ногоо нийлүүлж буй “Оюу Талст” ХХК, “Жаврай-Үр” ХХК, “Гэрэлт-Өртөөлөн” ХХК -ийн хүнсний ногоо нийлүүлэхийн өмнө хайрагдаагүй, гадаргуудаа шороо наалдаагүй, механик гэмтэл аваагүй, цагирган ялзрал болон питовтороор өвчлөөгүй, биологийн хагаралгүй төмс, хүнсний ногоог ялгалт хийлгэж, аюулгүй

байдлын шаардлагат нийцүүлэн хүлээн авч хэвшүүлж ажилласнаар төмс, хүнсний ногоог хорогдол хаягдалгүй болголоо.



Талбай болон нүхэн зоорь хэсгийн зурган танилцуулга





5. Захиалагчийн шаардлагад нийцсэн тендерийн материал боловсруулахад анхаарах зүйлс” сэдэвт сургалтыг “Гацуурт-Хүнс” ХХК-ийн сургалтын танхимд зохион байгуулж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу “Худалдан авах ажиллагааны сургалт зөвөлгөө өгөх төв” ТББ-тай хамтран Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын стандарт чанарын хяналтын улсын ахлах байцаагч Д.Жаргалсайхан, Стандарт чанарын хяналтын улсын байцаагч Б.Бархасбадь нар “Захиалагчийн шаардлагад нийцсэн тендерийн материал боловсруулахад анхаарах зүйлс”, “Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавигдах чанар, эрүүл ахуй, аюулгүйн шаардлага” сэдвүүдээр сургалт зохион байгуулж аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдav.



6. Байгууллагын үйл ажиллагаагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлж мэргэших, Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний “Ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх аргачлал” сэдэвт сургалтыг харилцагч байгууллагуудын менежерүүд СХД-ийн төрийн өмчит цэцэрлэгүүдийн эрхлэгч, нярав, эмч, тогооч нарыг хамруулж “Ул мөр мөрдөн тогтоох бүртгэлийн хуудас”, Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох “Урагш нэг шат”, “Хойш нэг шат” бүртгэлийн хуудсыг хөтлүүлж хэвшүүлж

үр дүнд хүргэв. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өмнөх шатны оролцогчоос хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хуудсын хамт хүлээн авч, "Урагш нэг шат", бүртгэлийг хүлээн авч "Хойш нэг шат" бүртгэлийн хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр тогтмол хөтөлж байна.

7. Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийн дагуу дараах зүйлүүдийг мөрдөн ажиллаж хэвшүүлж үр дүнд хүргэв.

Үүнд:

1. Мэргэжлийн сургалтын бүртгэл
 2. Лабораторийн сорилтын дүнгийн бүртгэл
 3. Хортон шавьж устгалын бүртгэл
 4. Татан авалт хийсэн бүртгэл
 5. Хортон шавьж устгалын бүртгэл
 6. Татан авсан хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн талаарх мэдээлэл
 7. Бичил цаг уурын бүртгэл
 8. Хөргөх төхөөрөмжүүдийн хэмийн бүртгэл
 9. Бэлэн бүтээгдэхүүн хадгалах цэвэрлэгээ ариутгал хийсэн тухай бүртгэл
 10. Их цэвэрлэгээ халдвартгүйтгэлийн бүртгэл
 11. Эрүүл мэнд, ариун цэврийн бүртгэл
 12. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний бүртгэл
 13. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын дотоодын хяналтын тогтолцоог эрүүл ахуйч эмч, хүнсний мэргэжилтэн, хүнсний няравууд хяналт хийж улирал тутам тайлан мэдээг тайлагнадаг боллоо.
8. Манай байгууллага нь жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг сургалтуудыг СХД-ийн төрийн өмчит 44 цэцэрлэг, Нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны Хүн эмнэлэг, 74-р сургуулийн дотуур байр зэрэг байгууллагуудын эрхлэгч, нярав, эмч, тогооч нарыг хамруулан "Хүүхдийн хоол тэжээл, сүү сүүн, бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага", "Хүүхдийн хоол тэжээл, гурил, гурилан бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага" сэдэвт сургалтуудыг зохион байгуулж ажилчдын хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд тавигдах шаардлага үйлдвэрлэлийн явц бүтээгдэхүүний онцлог чанар, орц найрлага хадгалах, хэрэглэх, зааваруудтай танилцаж туршлага судаллаа.



Хүүхдийн хоол тэжээл сүү, сүүн бүтээгдэхүүний чанар эрүүл ахуй, аюулгүйн шаардлага сэдэвт сургалт

Сургалтыг “Сүү” ХК-ийн сургалтын танхимд зохион байгуулж:

1. “Сүү” ХК-ийн үйл ажиллагааны танилцуулгыг Маркетингийн албаны дэд захирал Н.Болод,
2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа аюулгүй байдал, технологи, чанарын хяналтын лабораторийн танилцуулгыг Чанарын менежер Б.Байгаль,
3. СХД-ийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй халдварт хамгааллын улсын байцаагч Н.Нандинцэцэг
4. Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн тээвэрлэлт хадгалалт барийт бичгийн бүрдэл Үйлдвэр худалдаа үйлчилгээний улсын хяналтын байцаагч Б.Бат-Эрдэнэ нар сургалт явуулав.

Шинэ бүтээгдэхүүн:

Тараган ундаанд хүний биед агуулагдаж буй ашигтай пробиотек бактерууд нь ходоод, гэдэсний үйл ажиллагаа тэнцвэржүүлэх үүрэгтэй. Мөн ураг, кальци, витамин В-2, витамин В-12, кали болон магни ихээр агуулагддаг тул ясны сийрэгжилтээс сэргийлэж мөн эрүүл мэндийг дэмжих өндөр ач холбогдолтой хүнсний бүтээгдэхүүн юм.



- Гүзээлгэнтэй
- Интоортой
- Ааруул

АПУ ТРЕЙДИНГ ХХК сургалтын танхимд зохион байгуулж:



1. Сүүний үйлдвэрийн үйл ажиллагааны танилцуулгыг Хүнсний технологич Т.Сарантуюя

- Чанарын хяналтын лабораторийн танилцуулга, Чанарын албаны дарга Т.Золжаргал
- СХД-ийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй халдварт хамгааллын улсын байцаагч Н.Нандинцэцэг
- Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн, тээвэрлэлт хадгалалт баримт бичгийн бүрдэл Үйлдвэр худалдаа үйлчилгээний улсын хяналтын байцаагч Б.Бат-Эрдэнэ талаар сургалт явуулав.

Шинэ бүтээгдэхүүн

Хүүхдийн нас биений онцлогт тохирсон Сайн брэндийн Д амин дэмтэй сүү, иогурт үйлдвэрлэсэн танилцуулга хийв. Мэргэжилтнүүдийн тогтоосноор Д аминдээнийн дутагдал рахитнаас гадна нь 200 гаруй өвчний эрсдэлт хүчин зүйл болдог байна. Д аминдээм дутагдсанаар бага насын хүүхэд оройтож хөлд орно, бойжилт дутуу, хөл майга, толгой том зэрэг рахитын шинж илэрнэ. Сүү, тараг, загас, өндөг болон нарны гэрлээс Д амин дэмийг авах боломжтой. АПУ ХК Д амин дэмээр баяжуулж Сайн брэндийн Д амин дэмтэй сүү нэртэйгээр “Эрүүл амьдралын Энгийн жор” уриатайгаар хүргэж байна. Сайн Д амин дэмтэй сүү нь 500 гр савлагаатай, шууд уух зориулалттай өдөрт авах Д амин дэмийн зохистой хэмжээний 62,5%-ийг агуулдаг. Олон улсын хүнсний аюулгүй байдлын тогтолцоо ISO 22000-г Монголдоо анхлан нэвтрүүлсэн байна.



- Гүзээлзгэнэтэй йогурт
- Нэрстэй йогурт
- Тоортой йогурт



**Хүүхдийн хоол тэжээл гурил, гурилан бүтээгдэхүүний чанар
эрүүл ахуй, аюулгүй байдал сэдэвт сургалт**

Сургалтыг “АТАР-ӨРГӨӨ” ХК-ийн сургалтын танхимд зохион байгуулав.

- “АТАР ӨРГӨӨ” ХК-ийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн аюулгүй байдал, технологийн танилцуулгыг лабораторын эрхлэгч В.Баттуяа

2. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай” А/146 дугаар захирамжаар хүнс тээвэрлэлтийн тусгай зориулалтын бага оврын ачааны Mitsubishi fuso /FE71CBN4L/ 71 958 700 /Далан нэгэн сая есөн зуун тавин найман мянга долоон зуун/ төгрөгийн үнэ бүхий автомашиныг 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авч данс бүртгэлдээ бүртгэн ажиллаж байна. Машин техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг долоо хоног тутам шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийлгэж байна. Хүнсний бүтээгдэхүүнийг шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэхийн тулд машины чингэлэгийн цэвэрлэгээг тогтмол хийлгэж хэвшсэн. Машины эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээ, агаарын бохирдол, АТБӨЯХАТатвар, автозам ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлж техникийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.



Тайлан бичсэн: Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан

А.Мөнхболор

Дүгнэлт

“Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендер зарлаж шалгарсан аж ахуй нэгж байгууллагуудаас чанарын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хүлээн авч Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдийг чанартай хүнсний бүтээгдэхүүнээр захиалгын дагуу тухай бүрд нь санал гомдолгүй ханганд нийлүүлж, тайлангийн хугацаанд гадаад, дотоодын нэгдсэн нийт 16 сургалтанд холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулж, төлөвшүүлж мэргэшүүлснээр ажлын бүтээмж дээшилж ахиц гарч, Сонгинохайрхан дүүргийн сургуулийн өмнөх байгууллагад хоол хүнсээр дамжин халдвартлах хоолны хордлого, хордлогот халдварт гаргаагүй, аюулгүй байдлыг ханггуулж амжилттай ажиллалаа.

Цэцэрлэгт нийлүүлж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаар сургалт, өдөрлөг зохион байгуулан цэцэрлэгийн эрхлэгч нярав, тогооч, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдийн төлөөллүүдэд танилцуулан, санал хүсэлт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийж үнэлэлт дүгнэлт гаргаж, зөв зохистой хооллох дадал хэвшилд сургах арга зүйн мэдлэг өгснөөр хүнсний бүтээгдэхүүн хүлээн авахад тавигдах шаардлага, няравын үйл ажиллагаа, хоолны технологи, цэсний төлөвлөлт сайжирч хүүхдийн нас биений онцлогт тохирсон хоол хүнсээр тасралтгүй хангах үйл ажиллагааг явуулж ирсэн.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан нийт 40 гаруй байгууллагаас 26 цэцэрлэг буюу 60% нь бүтээгдэхүүний чанар болон үйлчилгээний талаар санал ируулсэн. Судалгааны дунд үнэлгээ хийхэд түгээлтэнд ажилладаг борлуулалтын нярав, ачигч, жолооч нарын харилцааны соёлыг харилцагч цэцэрлэгүүдийн ажилчид хүндэтгэлтэй зөв боловсон харьцаатай 100%, түгээж буй бүтээгдэхүүний 85% нь чанар сайн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан үзүүлэлт гарч байгаа нь хүүхдийн нас биений онцлогт тохирсон хоол хүнсээр хангаж ажилласныг харуулж байна.

Нийслэлийн Засаг даргын 40 дүгээр захирамжаар 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн “Хангамж төв” ОНӨААТҮГ байгууллагдаж 20 хүнийг ажлын байртай болгож, Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит 47 байгууллагад аюулгүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээр хангаж ашгийн бус үйл ажиллагааг явууллаа.

Байгууллагын ололт, амжилтыг бататган, хүнсний хангамжийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг улам сайжруулах, соёлтой бөгөөд түргэн шуурхай үйлчилж, цаашид хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

ХЯНАСАН:

“ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ

УЛААНБААТАР ХОТ

ХҮНС
ХАНГАМЖ ТӨВ
ОНӨААТҮГ

TTB83034-5443342

Ш.БУРМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

А.МӨНХБОЛОР